Хадгаламжийн банк тайлангийн хугацаанд нийт 134.9 мянган зээлдэгчид 53.2 тэрбум төгрөгийн зээл олгож, 130.4 мянган зээлдэгчийн 47.3 тэрбум төгрөгийн зээл төлүүлж, 28.3 мянган зээлдэгчийн 21.2 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан бөгөөд оны эхнээс үлдэгдэл 6.43 тэрбум төгрөгөөр өссөн байна.


Банк хоорондын захаар нийт 7 банкинд 2.7 тэрбум төгрөгийн зээл олгож, 7 банкны 2.96 тэрбум төгрөгийн зээл төлүүлж, эцсийн үлдэгдэл 0.8 тэрбум төгрөгийн шилжих үлдэгдэлтэй гарлаа.

2003 онд 2.88 тэрбум төгрөгийн зээлийн хүүний орлого олж байсан бол 2004 онд 4.95 тэрбум төгрөгийн зээлийн хүүний орлого

олсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 171.8 хувиар буюу 1.92 тэрбум төгрөгөөр өсч, зээлийн хүүний орлого нийт хүүний орлогын 70 гаруй хувийг эзлэх болсон байна.

Хадгаламжийн банк нь өөрийн эх үүсвэрээс зээл олгохоос гадна Дэлхийн банк, МУ-ын Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй АХБ-ны орон сууцны зээл, Бичил санхүүгийн хөгжлийн сангийн бичил зээл, гэр хорооллийн иргэдийг дэмжих гэр санаачлага төслийн зээлийг олгож, жижиг зээл олголтыг нэмэгдүүлэн харьяа нэгжүүдэд зээл олгох ажлыг эрчимжүүлсний дүнд өнгөрсөн онд салбаруудын ашигт ажиллагаа нэмэгдлээ. Орон нутгийн өвлийн бэлтгэлийг хангахад туслах зориулалтаар 5 аймгийн Дулааны станц, Эрчим хүчний үйлдвэрүүд, ДЦС-2 ХК, ДЦС-4 ХК, УБ ЦТС ХК зэрэг байгууллагуудад засварын болон нүүрс татан авалтын эх үүсвэрийг санхүүжүүлсэн нь орон нутгийг дэмжих, иргэдийн хэвийн амьдралыг хангахад тусалсан чухал санхүүжилт боллоо.

Зээлийн жигнэсэн дундаж хүү, 2004 он /сараар/



Зээлийн дундаж хүү 2004 оны эцэст 2.28 хувь гарсан нь арилжааны бусад банкуудын хүүнээс даруй 0.1-0.5 хувиар доогуур байна.

Сүүлийн 3 жилийн зээлийн шилжих үлдэгдлийг харьцуулбал: /Сая төгрөгөөр/



Зээлийн хүүний орлого сар тутам өсч, 2004 оны 1 дүгээр сард 313.0 сая төгрөгийн хүү олж байсан бол оны сүүлийн хагаст сард дунджаар 412.0 сая төгрөгийн хүү олдож даруй 31.6 хувиар өссөн байна.

Зээлийн багцийг өмчлөлийн бүтцээр ангилбал:



УУГ, Төрийн өмчийн ХК-д олгосон зээл нийт багцын 5.1 хувь буюу 2731.0 сая төгрөг байгаа нь ДДС-ХК, УБЦТС ХК, УБ хот, аймгуудын дулааны станц, ЦШСГ-т олгосон зээл гол хувийг эзэлж байна. Нийт үлдэгдлийн 38.6 хувийг иргэдэд олгосон зээл эзэлж байгаа нь зээлийн тархалтыг сайн хийж, эрсдлийг бууруулсан алхам болсон.

10.2. Хадгаламж, харилцах, хөрөнгө оруулалт

Тус банкинд 2004 оны 12-р сарын 31-ний байдлаар 218.3 мянган иргэд, байгууллагын харилцах, хадгаламжийн дансанд 50,383.4 сая төгрөгийн эх үүсвэр байршиж байна. Үүнээс харилцах дансанд 16,100.4 сая төгрөг, хадгаламжийн дансанд 34,283.0 сая төгрөг байршиж байна. 2004 онд хадгаламж, харилцах дансны үлдэгдэл 5,461.0 сая төгрөгөөр өсч, тэдгээрт 3,744.2 сая төгрөгийн хүү төлсөн байна.

Харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хадгаламжийн үйлчилгээний хугацаанд өөрчлөлт оруулж шинэ төрлийг гарган үйлчилгээнд нэвтрүүлсэн. Мөн нягтлан бодох бүртгэлийн BANCS программыг үйл ажиллагаанд нэвтрүүлж эхэлснээр харилцагч нарт үйлчилгээг шуурхай үзүүлэх боломжтой болж байна. 2004 онд төгрөгийн хугацаагүй хадгаламжийн хүүг 6.0

Хадгаламж, харилцах



хувь, хугацаатайг 12.0-16.8 хувиар, гадаад валютын хугацаагүй хадгаламжийн хүүг 2.4 хувь, хугацаатайг 6.0-8.4 хувиар мөрдөж ажиллалаа. Өнгөрсөн онд манай банкны харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл тогтвортой өсч байсан нь харилцагчдын тус банкинд итгэх итгэл өндөр байгааг харуулж байна.

Хадгаламжийн банкны картын
үйлчилгээ намайг бэлэн мөнгөний
эрсдлээс хамгаалдаг



10.3. Картын үйлчилгээ

Хадгаламжийн банк нь харилцагчдын тоо, үйлчилгээний хүрээ, салбарын сүлжээгээр Монгол улсын томоохон банкуудын нэг бөгөөд харилцагчдыг банкны үйлчилгээнд ойртуулахын тулд зах зээлд банкны шинэ дэвшилтэт бүтээгдэхүүнийг байнга нэвтрүүлж ирсэн. Үүний нэг тод жишээ нь Хадгаламжийн банк Монгол улсын банк санхүүгийн системд бэлэн бус төлбөр тооцооны дэвшилтэт хэлбэр болох дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн төлбөрийн картын системийг иж бүрэн нэвтрүүлэх зорилгоор 2003 оны 2-р сарын 19-нд Виза Интернэшнл байгууллагын үндсэн гишүүнээр элсч өөрийн нэрийн Виза картыг гаргасан явдал юм.

Тус байгууллага нь дэлхийн 150 оронд, 21 мянган банк, санхүүгийн байгууллага, 30 сая үйлчилгээний байгууллага, 700000 бэлэн мөнгөний машин АТМ-ээр үйлчилгээ үзүүлж байгаа нь тус байгууллага дэлхийд тэргүүлэх байр суурьтайг харуулж байна.

Хадгаламжийн банк тус байгууллагын жинхэнэ гишүүн болсноор харилцагчдад бэлэн бус төлбөр тооцооны дэвшилтэт хэлбэр VISA картын сүлжээнд нэгдэх боломжийг бүрдүүлж өгсөн.

Хадгаламжийн банк өнгөрсөн хугацаанд Виза интернэшнл, бусад Виза карт гаргасан гадаад дотоодын банкуудтай хамтын ажиллагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Тус банк одоогийн байдлаар дотоодод хэрэглэгдэх Виза карт гаргасан бөгөөд тус банкны карт эзэмшигч болсноор Худалдаа үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлэх, салбар тооцооны төвүүд, бэлэн мөнгөний машинаар үйлчлүүлэх зэрэг үйлчилгээнд хамрагдсанаас гадна Хадгаламж Виза картын бусад банкны картаас ялгарах онцлог нь орон сууцны болон тогтмол давтамжтай гарах төлбөр тооцоог картаараа дамжуулан төлөх боломжийг бүрдүүлэн аль болох харилцагчийн ая тухтай байдлыг бүрдүүлэн ажиллаж ирлээ.

10.4. Мессеж банкны үйлчилгээ

Хадгаламжийн банкнаас танд таны дансны мэдээлэл, картны үлдэгдэл, орон сууцны төлбөр, валютын ханшийг цаг алдалгүй хүргэх “SMS banking” үйлчилгээг үзүүлж байна.

Банк энэ үйлчилгээг Мобиком корпорациатай хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд харилцагчид шаардлагатай мэдээллийг мессеж хэлбэрээр таны гар утсанд дамжуулна. SMS banking үйлчилгээнд хамрагдахын тулд Та хадгаламжийн банкны харилцагч байх, гар утастай байх гэсэн нөхцөлийг хангах шаардлагатай. Харин харилцагч нь заавал бүртгүүлсэн байх ёстой.

Харилцагч энэ үйлчилгээнд хамрагдснаар түргэн шуурхай мэдээллээр хангагдаж, харилцах дансандаа хяналт хийх бололцоотой болж, цаг хугацаа, зардал хэмнэнэ.

11 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮНЭТ ЦААСНЫ УДИРДЛАГА


11.1 Засгийн газрын энгийн өрийн бичиг:

Манай банк 2004 онд 2.1 тэрбум төгрөгийн өрийн бичгийг мөнгөжүүлээд байна. Засгийн газрын энгийн өрийн бичгээс нийт 2,391.85 сая төгрөгийн хүүгийн орлого олсон. Хүүний түвшин 2, 3, 4 саруудад өмнөх саруудын хүүгийн түвшнээс 0.2 пунктээр буурсан нь Монголбанк 91 хоногийн үнэт цаасны нэрлэсэн хүүгийн түвшинг өмнөх арилжааны нэрлэсэн хүүгийн түвшнээс 5 пунктээр бууруулсан

буюу жилийн 10.0 хувиар зарласан нь нөлөөлсөн байна. 2004 оны хувьд өрийн бичгийн хүүгийн түвшин оны эхнээс өссөн хандлагатай байсан ба жилийн дундаж хүүгийн түвшин 1.33 хувь байлаа.

Тайлант онд Засгийн газрын энгийн өрийн бичгийн хүүний орлогоос 2,010.0 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн хэдий ч төлөвлөгөөг 19.3 хувиар давуулан биелүүлж ажиллалаа.

ЗГЭӨБичиг, ТБҮЦаасны хүүгийн түвшин



2004 онд Засгийн газрын энгийн өрийн бичгийн сарын дундаж хүү нь 1.33 хувь байгаа нь тайлант жилийн манай банкны хадгаламжийн жилийн дундаж хүүнээс (2004


оны 12 дугаар сарын 31-ны байдлаар хадгаламжийн жилийн дундаж хүү 0.84%) 0.49 пунктээр дээгүүр байна.

Засгийн газрын хямдруулсан бонд:

2004 онд 1,464.31 сая төгрөгийн 1,500.00 нэгж Засгийн газрын хямдруулсан бондыг нийт 2 удаагийн арилжаагаар Хөрөнгийн биржээр дамжуулан худалдан авч 35.7 сая төгрөгийн хүүгийн орлого оллоо.

Уг бондын хүүгийн түвшинг Засгийн газраас Монголбанкны үнэт цаасны хүүтэй ойролцоо буюу ижил түвшинд тогтоож ирсэн ба арилжааны явцад банкуудын өрсөлдөөний дүнд хүүгийн түвшин жилийн 8.55 хувь байсан байна. Хугацааны хувьд 30, 60, 90, 120, 150, 180 хоног байлаа.

ЗГХБ, ТБҮЦ-ны хүүгийн түвшин




11.2 Компанийн бонд

Хөрөнгийн биржээр арилжаалагдаж байгаа Барилга үйлдвэрлэлийн “Барилга” корпораци, “Алтан хот” корпорацийн гаргаж байгаа бондын арилжаанд оролцож, 2004 онд нийт 693.3 сая төгрөгийн бонд худалдан авч, 749.0 сая төгрөгийн бонд төлөгдөж, 156.3 сая төгрөгийн хүүгийн орлого авч, 2004 оны 12 сарын 31 -ний байдлаар 871.4 сая төгрөгийн бондын үлдэгдэлтэй байна.

11.3. Төв банкны үнэт цаас

Манай банк Монголбанкнаас тогтоосон Заавал байлгах нөөцийн шаардлагыг хангаж ажиллан илүүдэл нөөцөөр Монголбанкны үнэт цаасны арилжаанд оролцож ирлээ. 2004 онд нийт 48 удаагийн худалдан авалтаар өссөн дүнгээр 77.7 тэрбум төгрөгийн үнэт цаас худалдан авч 299.7 сая төгрөгийн хүүгийн орлого олсон. Тайлант оны Төв банкны үнэт цаас худалдан авалт, ТБҮЦ-ны хүүгийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад ТБҮЦ худалдан авалт 90.9 тэрбум төгрөг буюу 53.9 хувь, хүүгийн орлого 384.0 сая төгрөг буюу 43.8 хувиар тус тус өссөн байна.

Төв банк үнэт цаасны хүүгийн орлого /сая ₮/




12 БАНКНЫ ГАДААД ХАРИЛЦАА

Корреспондент харилцаа:

Хадгаламжийн банк нь 2001 оны 11 дүгээр сард Монгол банкнаас гадаад гүйлгээний эрх авснаар өөрийн бие даасан гадаад гүйлгээний үйл ажиллагааг явуулж эхэлсэн. Тус банк анх дэлхийн томоохон арилжааны банк болох HongKong & Shanghai Banking Corporation-тай корреспондент харилцаа тогтоож харилцагчдын гадаад гүйлгээг зөвхөн ам.доллараар хийж байсан бол 2004 оны эцэс гэхэд дэлхийн эдийн засаг, гадаад худалдааны төлбөрийн гол валют ам.доллар, евро болон японы иенээр харилцагчдын гадаад төлбөрийн гүйлгээг хурдан шуурхай, найдвартайгаар богино хугацаанд хийж гүйцэтгэж байна.

Энэ хугацаанд Хадгаламжийн банк гадаад үйл ажиллагааныхаа хүрээг тэлж Union Bank of California, Credit Swiss First Boston, Bayerische Hypo and Vereinsbank AG, Sumitomo Mitsui Banking Corporation зэрэг Ази, Европ, Америкийн олон улсад нэр хүнд бүхий банкуудтай ажил хэргийн холбоо тогтоон ажиллаж байна.

Гадаадын гүйлгээний динамик өсөлт



Олон улсын байгууллагууд:

Дэлхийн Хадгаламжийн Банкуудын Холбоо:

Хадгаламжийн банкны үйл ажиллагааны гол хэсэг бол нэг шатлалтай банкны системийн үеэс уламжлагдаж ирсэн иргэдийн хадгаламжийг найдвартай хадгалж өсгөн үржүүлэх үйл ажиллагаа юм. Иргэдийн хадгаламжийн үйл ажиллагааг голчлон явуулж ирсэн тус банк нь гадаад орнуудын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг банкуудтай харилцаа холбоо тогтоон ажилласны үр дүнд дэлхийн 99 орны 109 банкуудыг эгнээндээ нэгтгэсэн Дэлхийн Хадгаламжийн Банкуудын Холбоонд 1999 онд жинхэнэ гишүүнээр элсэж, тус байгууллагын олон талт үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирлээ. Хадгаламжийн банкны идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд тус ДХБХолбоо болон Францийн Үндэстний Хадгаламжийн Банкуудын Холбоотой хамтран 2004 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо “Эрсдлийн удирдлага” сэдэвт сургалт семинарыг амжилттай зохион байгууллаа. Мөн ДХБХ-ны хамтын ажиллагааны хүрээнд тус банкны төлөөлөгч нар 2004 оны 10 дугаар сард Францийн Үндэстний Хадгаламжийн Банкуудын Холбоонд зочилж Францийн банкны систем болон тус байгууллагын үйл ажиллагаатай танилцаж цаашид хамтран ажиллах талаар санал солилцлоо. 2004 оны 5 дугаар сард Тайландын Бангкок хотноо хуралдсан ДХБХ-ны Ази Номхон далайн орнуудын бүсийн 10 дугаар чуулга уулзалтанд тус банкны төлөөлөгчид оролцож, Монгол улсын банкны систем сэдэвт илтгэл тавьж тус чуулганы төлөөлөгчдийн дунд ярилцлага зохион байгууллаа.


Олон улсын банк хоорондын төлбөр тооцооны SWIFT сүлжээ:

Хадгаламжийн банк 2002 оны 3 дугаар сард олон улсын банк хоорондын төлбөр тооцооны SWIFT /Society for Worldwide Interbank Financial Telecommunication/ байгууллагын гишүүнээр элсэж улмаар 2002 оны 6 дугаар сард энэ сүлжээнд холбогдсон. 2004 оны 5 дугаар сард Хадгаламжийн банк олон улсын SWIFTNet-д холбогдсоноор тус банкны харилцагчдын гадаад төлбөр тооцоог улам хурдан шуурхай, найдвартай явуулах бололцоог бүрдүүллээ.

Олон улсын мөнгөн гуйвуулгын MONEYGRAM сүлжээ:


MONEYGRAM сүлжээ нь дэлхийн 155 гаруй оронд байрлах 55000 гаруй үйлчилгээний цэгүүдээр үйлчилгээ явуулж байна. Хадгаламжийн банк олон улсын MoneyGram үйлчилгээний сүлжээнд 2003 оны 3 дугаар сард холбогдож тус банкны нийслэл болон хөдөөний салбар, тооцооны төвүүдээр дамжуулан хувь хүмүүс иргэдэд гадаадад ажиллаж амьдарч, сурч байгаа ойр дотны хүмүүстээ болон тэднээс 10 минутын дараа төлбөр хүлээн авах эсвэл төлбөр явуулах боломжийг бүрдүүллээ.

Money Gram-аар мөнгө шилжүүлсэн болон хүлээн авсан нийт дүн /USD/



Хадгаламжийн банк 2004 онд Азийн Хөгжлийн Банк, Европын сэргээн Босголт Хөгжлийн Банк, USAID зэрэг бусад олон улсын байгууллага, банкуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж ирлээ.

Үйлчлүүлэгчдийн тоо



13 САНХҮҮГИЙН ТАЙЛАН

13.1 Ашиг, алдагдал

2001 оноос банкны хязгаарлагдмал үйл ажиллагааг арилжааны хэлбэрт шилжүүлэх үйл явц улам идэвхжиж, нэгдсэн бодлогын хүрээнд бүх төрлийн зээл олгох, гадаад төлбөр тооцооны болон банкны бусад үйл ажиллагаа, мөн банк санхүүгийн зах зээлд шинэ үйлчилгээнүүдийг нэвтрүүлснээр банкны ашигт ажиллагаа сайжирч, 2004 онд 1017.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна



13.2 Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

2004 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бэлэн мөнгө ба богино хугацааны хөрөнгө оруулалт 17.1 тэрбум төгрөгт хүрч тус

банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 34.45 болсон нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сайн байгааг харуулж байна.

13.3 Тайлан тэнцэл

2004 оны эцэст нийт пассивын 67.41 хувь буюу 34.2 тэрбум төгрөгийн иргэдийн хадгаламж, 28.45 хувь буюу 14.4 тэрбум төгрөгийн харилцах дансны үлдэгдэл эзлэх болсон байна.

Банкны нийт тэнцэл өмнөх оноос 6.1 тэрбум төгрөгөөр өсөж, дүрмийн сангийн хэмжээг 1,391.6 сая төгрөгөөр нэмэгдүүлээ.

Банкны ашигт ажиллагаа жилээс жилд нэмэгдэж байгаа болон дүрмийн сангийн хэмжээ нэмэгдсэн нь нийт хөрөнгийн хэмжээ нэмэгдүүлэхэд нөлөөллөө. Өөрийн хөрөнгө нэмэгдсэн нь шалгуур үзүүлэлтүү-

дийг тогтвортой хангах нөхцөл бүрдэж пассивын бүтэц сайжирч байна.

Банк бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 67.3 хувийг орлого оруулах активт байршуулсан байгаа нь банкны ашигт ажиллагаанд эергээр нөлөөлж байна.




13.4 Орлого



2004 оны жилийн эцсийн байдлаар нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 хувь буюу 1.1 тэрбум төгрөгөөр өсөж, 8.6 тэрбум төгрөгт хүрлээ. Орлогын энэ өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйл бол зээлийн хүүний орлого, Монголбанкны үнэт цаасны хүүний орлого юм.

ЗГЭӨБ-ийн /бүтцийн өөрчлөлтийн/ орлогын нийт орлогод эзлэх хувь 2001 онд 78.3 хувь буюу 4.6 тэрбум, 2002 онд 66.8 хувь буюу 4.3 тэрбум төгрөг, 2003 онд 39.3

2004 онд нийт орлогод хүүгийн бус орлого 8.0 хувь буюу 689.24 сая төгрөг болсон байна. Хүүгийн бус орлогын дийлэнх хэсгийг төлбөрт үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого эзэлж байна. Уг орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.




хувь буюу 3.0 тэрбум төгрөг, 2004 онд 28.3 хувь буюу 2.4 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон нь банк арилжааны хэлбэр идэвхитэй шилжиж байгааг харуулж байна.



13.5 Зардал

Нийт зардал 2004 онд 7356.8 сая төгрөг болсон ба нийт зардлын бүтцийг дараах байдлаар харуулав. Хадгаламжийн банк 2001 оноос эхлэн улсын төсөвт татвар төлж эхэлсэн ба татварын зардал 2001 онд 92.0 сая төгрөг, 2002 онд 151.1 сая төгрөг болжээ. 2003 онд УТЕГ-аас банкинд 2003, 2004 онуудад тус тус 100.0 сая төгрөгийн татвар ноогдуулсныг оны эцэст бүрэн төлж дууссан



13.6 Эрсдлийн удирдлага

Манай банк эрсдлийг хянах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ажилтан бүрийн эрх үүргийг тодорхойлох, ажилбар бүрт мөрдөх заавар, журмыг боловсруулж түүгээрээ дамжуулан ажил үүргийн хязгаарлалтыг хийж харилцагчийн итгэлийг дааж ажиллах нь банкиг төлбөрийн чадварын эрсдлээс хамгаалах гол хүчин зүйл болж байна. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд харилцагчийн төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх, тэдний хүссэн хэмжээнд хөнгөн шуурхай үйлчлэх чиг бодлогыг баримталж, нягтлан бодох бүртгэлийн хяналтыг сайжруулах, техник ажиллагааг хөнгөвчлөхөд чиглэгдсэн шинэ программыг нэвтрүүлэн ажиллаж байна.

Үүний зэрэгцээгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж өргөжихийн хэрээр банкны үйл ажиллагаан дахь эрсдлийн хэлбэр хэмжээ нэмэгдэх магадлал өндөр болдог.

Ийм учраас ажилтнуудын эрх үүрэг хариуцлагын хязгаартай байдал хэрхэн мөрдөгдөж байгаа, дотоод хяналтын системийг оновчтой хэрэгжүүлж, үйл ажиллагааны эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн арга замыг зөв тодорхойлон ажиллаж ирснээр манай банк Монгол банкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг сар дараалан биелүүлж ирлээ.

А У Д И Т Ы Н Т А Й Л А Н

14 АУДИТААР БАТАЛГААЖУУЛСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН



KPMG (Firm No. AF 0758)
Chartered Accountants
Wisma KPMG
Jalan Dungun, Damansara Heights
50490 Kuala Lumpur, Malaysia

Telephone +60 (3) 2095 3388
Fax +60 (3) 2095 0971
Internet www.kpmg.com.my

Бид Монгол улсын Хадгаламжийн банкны 5-28 хуудсан дахь санхүүгийн тайлангуудад аудит хийлээ. Банкны Захирлуудын Зөвлөл нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэх үүрэгтэй. Бидний үүрэг бол өөрсдийн хийсэн аудит дээр үндэслэн санхүүгийн тайлангууд дээр дүгнэлт гаргах явдал юм.

Бид аудит хийхдээ Олон Улсын Аудитын Стандартыг мөрдлөгө болгосон. Санхүүгийн тайлангууд нь материаллаг үзүүлэлтийнхээ хувьд алдаа зөрчилгүй гэдэг үндэслэлээр магадлах нотолгоо олж авахын тулд шаардлагатай гэж үзсэн бүх мэдээлэл, тайлбаруудыг олж авахуйцаар төлөвлөж, гүйцэтгэхийг эдгээр стандартууд нь шаарддаг. Аудит хийхдээ санхүүгийн тайлан дахь дүн, тайлбар тодотголыг нотлохдоо түүврийн аргаар шалгадаг. Түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, зарчим болон удирдлагын хийсэн үлэмж хэмжээний тооцооллыг шалгаж, үнэлэхээс гадна санхүүгийн тайлан дахь мэдээллийг ерөнхийдөө шаардлагын дагуу тайлагнасан эсэхэд үнэлгээ өгдөг. Бидний хийсэн аудит нь гаргасан дүгнэлтэнд зохих үндэслэл болж чадна гэдэгт бид итгэж байна.

1. Монгол Банкны Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журмын шаардлагаар банк 2004 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бүх зээлэндээ 1 хувийн зээлийн ерөнхий эрсдлийн сан байгуулж орлогын тайланд тусгасан нь ойролцоогоор 212.2 сая Г байна /2003: 155.5 сая Г/. Гэвч энэ нь Олон улсын Санхүүгийн бүртгэлийн дараах стандартуудыг зөрчиж байна.

А. Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт 39 – Санхүүгийн хэрэгслүүд: Танин мэдэхүй ба хэмжилт /IAS 39/ гэсэн зүйл ангид зээл олгогдсон үед ирээдүйд учрах алдагдлыг сан байгуулах замаар алдагдлыг тооцохыг хориглодог,

В. Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт 30 – Банк болон түүнтэй адилтгах санхүүгийн байгууллагуудын санхүүгийн тайлангууд гэсэн зүйл ангид заахдаа 1 хувиас илүү байгуулсан ерөнхий эрсдлийн санг хуримтлагдсан орлогод хамааруулан бүртгэлд тусгахыг шаарддаг.

2. Банкны чанаргүй зээл болон зээлийн алдагдлын сангийн хэмжээг тодорхойлох аргачлал нь дараахь зүйлсэд тулгуурлажээ. А. Чанаргүй зээлийг ангилахдаа гол төлөв зээлийн үндсэн төлбөрийн эцсийн төлж дуусах хугацаанаас хугацаа хэтрэлтийн хоногийг тооцон ангилдаг ба зээлийн үндсэн төлбөр, хүүгийн зээл төлөлтийн хуваарийн хугацаа хэтрэлтийг тооцдоггүй байна. Энэ нь Монгол банкны Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж зарцуулах журмын зээлийн үндсэн төлбөр болон хүүний төлөлтийн хуваарийн хугацаа хэтрэлтийг чанаргүй зээлийг ангилахдаа тооцно гэсэнтэй зөрчилдөж байна.

В. Банк зээлийг ангилахдаа зээлдэгчийн эргэн төлөх чадварыг голлон анхаарч зээлийн үндсэн төлбөр, хүүгийн хугацаа хэтэрсэн хоногуудыг орхигдуулсан нь Монгол банкны Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж зарцуулах журмын зээлийн үндсэн төлбөр болон хүүний хугацаа хэтрэлтийн хоногийг зээлийг ангилахдаа голлон анхаарна гэсэнтэй зөрчилдөж байна.

Бидний 2004 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бүх зээлийн 36 хувь дээр хийсэн шалгалтаар Монгол банкны эрсдлийн сан байгуулах бодлогыг баримталбал банк ойролцоогоор нэмж 113 сая Г-ийн зээлийн эрсдлийн сан байгуулах шаардлагатай. Банк нэмж байгуулах энэ нэмэлт зээлийн эрсдлийн санг санхүүгийн тайландаа оруулсан. Монгол банкны Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж зарцуулах журамд зохицуулан бидний шалгаагүй бусад зээлийн хувьд нэмэлт зээлийн эрсдлийн сан ямар хэмжээтэй байх талаар бид тодорхойлох боломжгүй.


Бидний 2003 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайлангуудад хийсэн аудитын тайланд зээлийн эрсдлийн сан байгуулсан асуудлаар дүгнэлт гаргаж, банк зээлийн эрсдлийн санг дутуу байгуулсныг тогтоосон.

Бидний 2003 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бүх зээлийн 32 хувь дээр хийсэн шалгалтаар банкны зээлийн эрсдлийн сан ойролцоогоор 119 сая Г -өөр байгуулах шаардлагатайг тогтоосон бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэхийг бид анхааруулсан. Бидний шалгаагүй бусад зээлийн хувьд нэмэлт зээлийн эрсдлийн сан ямар

хэмжээтэй байх талаар бид тодорхойлох боломжгүй.

3. Өмчийн хувьд 1998 онд Засгийн газрын шийдвэрээр Хадгаламжийн банкинд шилжүүлсэн 17 орон сууцны бүртгэлийн үнэ нь 124 сая төгрөг /засвар өргөтлийн 86 сая төгрөгийг оруулаад/ бөгөөд засгийн газраас эдгээр орон сууцыг эргүүлэн өгөхийг шаардаж байгаа болно. Банк эдгээр орон сууцыг өөртөө үлдээхийн тулд Засгийн газартай ярилцаж байна. Хэдийгээр энэ асуудал шийдэгдээгүй боловч банк эдгээр орон сууцыг өөрийн хөрөнгөнд бүртгэсээр байна. 2003 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайлангуудад хийсэн аудитын тайланд бид мөн энэ талаар дүгнэлт гаргасан. 2003 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар эдгээр орон сууцнуудын цэвэр бүртгэлийн үнэ нь 39 сая Г байсан.

Бидний саналаар дээр дурьдагдсан зүйлсээс бусад 5-28 дугаар хуудсанд байгаа санхүүгийн тайлангууд нь үнэн зөв, материаллаг шинжтэй. 2004 оны 12 дугаар сарын 31-ний Хадгаламжийн банкны бодит байдлыг илэрхийлсэн бөгөөд банкны тухайн жилийн үр дүн, мөнгөн урсгал Олон улсын санхүүгийн бүртгэлийн стандартын дагуу энэ хугацаанд дуусгавар болсон.



КПМЖ
Куала Лумпур
Малайз улс

2004 оны 12 сарын 31-ээр дуусгавар болсон орлого үр дүнгийн тайлан

	Тайлбар	2004 мян.төг	2003 мян.төг
Хүүгийн орлого	1	7,912,972	7,017,593
Хүүгийн зардал	2	(3,845,289)	(3,772,702)
Хүүгийн цэвэр орлого		4,067,683	3,244,891
Цэвэр шимтгэл ба хураамжийн орлого	3	497,542	417,133
Гадаад валютын арилжаа ба ханшийн тэгшитгэлийн цэвэр ашиг, алдагдал		50,217	63,389
Бусад үйл ажиллагааны орлого		66,911	92,962
Хүүгийн бус орлого	4	614,670	573,484
Үйл ажиллагааны орлого		4,682,353	3,818,375
Үйл ажиллагааны зардал		(2,976,559)	(2,353,400)
Үнэ бууралтын алдагдал	5	(588,226)	(159,875)
Татварын өмнөх ашиг	6	1,117,568	1,305,100
Татвар		(100,000)	(100,176)
Татварын дараах ашиг	7	1,017,568	1,204,924
Нийгмийн хөгжлийн санд оруулсан хөрөнгө		(204,323)	(698,553)
Жилийн цэвэр ашиг		813,245	506,371

2004 оны 12 сарын 31-нээрх тайлан тэнцэл

Актив	Тайлбар	2004	2003
		мян.төг	мян.төг
Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хэрэгсэл	8	12,810,378	8,265,996
Банкуудад байршуулсан хөрөнгө		2,572,540	570,080
Дамжуулан худалдах гэрээгээр авсан үнэт цаас		-	-
Гүйлгээнд гаргах боломжтой хөрөнгө оруулалтын үнэт цаас	9	17,140,600	24,385,616
Зээл ба урьдчилгаа төлбөр	10	21,168,507	15,374,114
Бусад хөрөнгө	11	731,981	802,867
Өмч, тоног төхөөрөмж		2,475,584	1,343,718
Нийт актив		56,899,590	50,742,391
Пассив, өөрийн хөрөнгө			
Харилцагчдын харилцах, хадгаламж	12	45,169,446	44,922,389
Бусад банкнаас авсан хадгаламж	13	4,000,000	-
Татварын өглөг		-	-
Бусад өр төлбөр		2,537,814	1,832,516
Нийт пассив		51,707,260	46,754,905
Дүрмийн сан	14	4,000,000	2,608,401
Нөөцийн сан		1,192,330	1,379,085
Нийт өөрийн хөрөнгө		5,192,330	3,987,486
Нийт пассив, өөрийн хөрөнгө		56,899,59	50,742,391

1. Хүү ба түүнтэй адилтгах орлого

	2004	2003
	мян.төг	мян.төг
Зээл ба урьдчилгаа	4,951,188	2,837,358
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	2,947,994	3,385,891
Бусад банкинд байшуулсан хөрөнгө	13,790	794,344
	7,912,972	7,017,593

3. Цэвэр шимтгэл хураамжийн орлого

	2004	2003
	мян.төг	мян.төг
Цэвэр шимтгэл хураамжийн орлого	513,197	428,662
Цэвэр шимтгэл хураамжийн зардал	(15,655)	(11,529)
	497,542	417,133

5. Үйл ажиллагааны зардал

	2004	2003
	мян.төг	мян.төг
Ажилтнуудын зардал	1,072,174	904,636
Нийгмийн ба эрүүл мэндийн даатгалын зардал	241,621	174,926
Элэгдэл	238,730	155,717

7. Татвар

	2004	2003
	мян.төг	мян.төг
Орлогын татвар	100,000	151,740

2. Хүү ба түүнтэй адилтгах зардал

	2004	2003
	мян.төг	мян.төг
Харилцагчийн хадгаламж	3,744,192	3,736,920
Хадгаламж ба банкнаас гаргаж байршуулсан	101,097	35,782
Бусад банк болон	3,845,289	3,772,702

4. Үйл ажиллагааны бусад орлого

	2004	2003
	мян.төг	мян.төг
Хожимдсон төлбөрийн шимтгэл	28,235	36,038
Өмч хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж борлуулсны орлого	-	-
Бусад орлого	38,676	56,924
	66,911	92,962

6. Нөөцийн сангууд

	2004	2003
	мян.төг	мян.төг
Зээлийн алдагдлын сангууд	584,938	112,994
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	(13,212)	21,926
Бусад сангууд	16,500	24,955
	588,226	159,875

8. Мөнгө түүнтэй адилтгах орлого

	2004	2003
	мян.төг	мян.төг
Бэлэн мөнгө	5,277,571	2,439,916
Монгол банкинд байгаа үлдэгдэл	6,035,293	4,692,639
Бусад банкинд байгаа үлдэгдэл	1,497,514	1,133,441
	12,810,378	8,265,996

9. Үнэт цаас

	2004 мян.төг	2003 мян.төг
Монгол банкны үнэт цаас	2,277,914	6,160,230
Засгийн газрын үнэт цаас	14,000,000	16,100,000
Бусад өрийн үнэт цаас	871,400	2,147,312
	17,149,314	24,407,542
Хөрөнгийн өртгийн бууралтын алдагдлын сан	(8,714)	(21,926)
	17,140,600	24,385,616

10. Зээл ба урьдчилгаа

	2004 мян.төг	2003 мян.төг
Арилжааны зээл	15,440,701	11,472,817
Тэтгэврийн зээл	2,851,135	1,373,925
АХБ-ны ХАА/ орон сууцны санхүүжилтийн төслийн зээл	1,906,854	1,040,797
Банк хоорондын зээл	800,000	1,000,000
Ажилчдын зээл	443,414	46,957
Бусад	489,636	617,913
	21,931,740	15,552,409
Зээлийн алдагдлын сан	(763,233)	(178,295)
Нийт цэвэр зээл ба урьдчилгаа	21,168,507	15,374,114

ХАА-н болон орон сууцны санхүүжилтын зээлийн 75% нь АХБ-наас санхүүжигдсэн байна. Бусад зээлд зээлийн урьдчилгаа, цалингийн зээл, оюутны зээл, жижиг зээлүүд орно.

11. Бусад хөрөнгө

	2004 мян.төг	2003 мян.төг
Авлагууд	585,300	747,960
Авлагын хүү	108,744	74,236
Урьдчилан төлсөн зардал	206,524	241,112
Өргөн хэрэглээний ба бусад эд хөрөнгө	401,326	292,972
Эзэмшиж байгаа бусад үндсэн хөрөнгө	15,960	15,960
	1,317,854	1,372,240
Авлагын сан	(569,913)	(563,413)
Үндсэн хөрөнгийн бууралтын алдагдлын сан	(15,960)	(15,960)
	731,981	802,867

12. Харилцагчдын харилцах хадгаламж

	2004 мян.төг	2003 мян.төг
Харилцах данс	10,800,369	9,256,225
Хадгаламжийн данс	7,344,473	7,665,289
Хугацаатай хадгаламж	26,938,494	27,830,602
Бусад хадгаламж	86,110	170,273
	45,169,446	44,922,389

13. Бусад өр төлбөр

	2004 мян.төг	2003 мян.төг
Азийн хөгжлийн банкны зээл	1,063,453	701,932
Дэлхийн банкны зээл	150,489	-
Хуримтлагдсан хүү	731,695	389,924
Нийгмийн хөгжлийн сан	412,411	564,164
Бусад өглөг	179,766	176,446
	2,537,814	1,832,516

14. Дүрмийн сан

	2004 мян.төг	2003 мян.төг
1р сарын 1-ний байдлаар	2,608,401	2,217,300
Жилийн турш дахь есөлт	1,391,599	391,101
12-р сарын 31-ны байдлаар	4,000,000	2,608,401

15 ХАДГАЛАМЖИЙН БАНКНЫ ДОТООД ХЯНАЛТЫН СИСТЕМ

Тус банкны дотоод хяналтын газар нь эрсдлээс урьдчилан сэргийлэх, удирдлагыг мэдээллээр хангаж оновчтой шийдвэр гаргахад чиглэгдэж ажилтан бүрийн хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, банкны үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, ашиг орлогыг нэмэгдүүлэх бүх салбар нэгжийн болон нийт ажилтнуудын ажлын эрх, үүргийн хэм хэмжээг дүрэм журмаар тогтоон түүнд дараалсан хяналт шалгалтыг хийх замаар иж бүрэн хяналтын системийг хэрэгжүүлж байна.

Удирдлагыг оновчтой шийдвэр гаргахад дотоод хяналт шалгалтын мэдээллийн үүргийг дээшлүүлэх, заавар журамд өөрчлөлт оруулах, ажил үүргийн хуваарийг

зөрчсөн ажилтнуудад арга хэмжээ авах зэргээр эрсдлээс хамгаалахад дараалсан хяналтын үүрэг чиглэгдэж байна.

Заавар журмын заалтуудыг нэг бүрчлэн хэрэгжүүлэх, ажилтнуудын ажил гүйцэтгэх мэдлэг чадвар, хариуцлагыг өндөржүүлэх замаар бүх төрлийн эрсдлээс сэргийлэхэд дотоод хяналт чухал үүрэг гүйцэтгэж байна.

Өнгөрсөн онд салбар нэгжүүдийн бүх төрлийн ажилд онооны үнэлгээг хангалттай, хангалтгүй гэсэн 2 хэлбэрээр дүгнэж хангалтгүй үнэлгээ авсан буюу эрсдэл гарч болзошгүй салбар, нэгж, ажилбар болон түүнийг гүйцэтгэж буй ажилтнуудад мэргэжлийн зааварчлага зөвлөмж өгч ажиллав.

16 БАНКНЫ МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛТ, ХӨГЖИЛ

Мэдээлэл Технологийн хэлтэс нь 2004 онд мэдээлэл технологийн орчин үеийн ололт амжилтуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, банкны программ хангамжийг шинэчлэх, боловсронгуй болгох, салбар нэгжүүдийн хоорондын мэдээллийн уялдаа холбоог зохицуулах талаар ихээхэн анхаарал тавьж, ажиллаж ирлээ.

1. Банкны бүртгэл тооцоо болон дотоод ажиллагааг автоматжуулах зорилготойгоор олон улсын бүртгэлийн системд тохирсон орчин үеийн програм хангамж BANCS системийг нэвтрүүлж эхлэв. Энэ системийг нэвтрүүлснээр данс нээсэн газраас үл хамааран аль ч салбар нэгж дээр орлого, зарлагын гүйлгээ хийх боломжийг олгоно. Bancs системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан сүүлийн үеийн өндөр хүчин чадалтай сервер болон тоног төхөөрөмжүүдийг суурилуулав.
2. Банкны төв болон салбарууд хооронд радио модем болон VSAT ашигласан онлайн сүлжээг татсанаар бүх салбарууд онлайн горимд ажиллаж харилцагчид, хадгаламж эзэмшигчид хүссэн үедээ аль ч салбарт очиж үйлчлүүлэх боломжтой болов.
3. VISA картын үйлчилгээг нэвтрүүлсэнтэй холбогдуулан тус банкны харьяа 33 тооцооны төв, 400 гаруй үйлчилгээний цэгүүдээс бэлэн мөнгө авах болон бэлэн бус гүйлгээг хийх техникийн болон програм хангамжийн шинэчлэл өөрчлөлтийг хийв. Мөн түүнчлэн олон улсын VISA international карт нэвтрүүлэхтэй холбогдуулан шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулах, тэдгээртэй холбоотой тестүүдийг хийж байна.
4. Орон сууц, СӨХ, Кабель, Цахилгааны төлбөрийг хүссэн тооцооны төвөөс хийх бололцоог олгох программыг нэвтрүүлж байна.
5. SMS banking үйлчилгээг нэвтрүүлснээр харилцагчид гар утаснаасаа дансны мэдээлэл, картын үлдэгдэл, орон сууцны төлбөр, валютын ханшийг цаг алдалгүйгээр мэдэх бололцоотой болов.

17 БАНКНЫ САЛБАРУУД, САЛБАРЫН УДИРДЛАГА

Хадгаламжийн банкны салбар нэгжийг оновчтой удирдан зохион байгуулснаар бүх салбар нэгжээр банкны шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэн 2004 оны эцсийн байдлаар Улаанбаатар хотод төв банк, 32 тооцооны төв 1 касс, хөдөө орон нутагт 7 салбар нийт 41 салбар нэгжээрээ дамжуулан харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Улаанбаатар хот дахь тооцооны төвүүдийн сүлжээний байршил, эзлэхүүнээр бусад банкнаас илүү байгаа нь банкны цогц үйлчилгээг харилцагчиддаа хүргэхэд чухал ач холбогдолтой байна.

Харилцагчдад түргэн шуурхай үйлчлэх гол нөхцөл нь банкны программ хангамж, дотоод сүлжээний зохион байгуулалт сайн байх явдал юм. Иймд банкны программ хангамжийг сайжруулах, сүүлийн үеийн техник технологийг нэвтрүүлэх ажлыг төв

банк төдийгүй бүх салбар нэгжүүдэд анхаарч ирснээр Улаанбаатар хот дахь тооцооны төвүүд радио модем ашиглан сүлжээнд холбогдож төлбөр тооцоог online горимд түргэн шуурхай гүйцэтгэх болсон.

Хөдөө орон нутгийн салбаруудыг VSAT-ийн антен ашиглан төв банктай холбосноор мэдээлэл шуурхай солилцдог боллоо.

Орон сууц, контор болон КАТВ-үүдтэй offline горимд сүлжээнд холбогдон цаасаар мэдээлэл солилцохоо больж манай банкны 26 тооцооны төв уртасгасан цагаар ажиллаж тэтгэвэр тэтгэмж тавих, орон сууцны орлого хураах зэрэг үйлчилгээ үзүүлж, тооцооны 1 дүгээр төв 24 цагаар ажилласнаар хадгаламжийн гүйлгээ хийх, валют солих, картаар үйлчлэх, үнэт зүйл хадгалах, харилцах дансны үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд 2005 онд салбар болгон өргөжүүлэх ажлын бэлтгэлийг бүрэн хангаад байна.

№	Салбарын дугаар	Аймгийн нэр	Захирал	Ерөнхий Ня-бо
1	1601	Баян-Өлгий	01-422-22978	01-422-22493
2	1602	Баянхонгор	01-442-22794	01-442-22894
3	1603	Дархан-Уул	01-372-23190	01-372-27731
4	1604	Орхон	01-352-21978	01-352-22626
5	1606	Увс	01-452-22680	01-452-22760
6	1607	Ховд	01-432-23722	01-432-22014
7	1608	Хөвсгөл	01-382-23076	01-382-24025

18 ХАРИЛЦАХ ХАЯГ

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

1-р салбар

1-р хороо, бага тойруу, 1-р дечин мянгат 7А
Утас: 330394

Тооцооны 4-р төв

2-р дечин мянгат, 3-р хороо, 15-р байр
Утас: 327948

Тооцооны 5-р төв

13-р хороо, 5 буудалд
хуучнаар 57-р дэлгүүрийн 2-р давхарт
Утас: 357043

Тооцооны 8-р төв

4-р хороо, 6-р байр /Горькийн номын сан/
Утас: 328448

Тооцооны 23-р төв

2-р хороо, 50 мянгат, 21-р байр
Утас: 324693

Тооцооны 25-р төв

5-р хороо, 6-р хороолол
ЧД-ийн МАХН-ын байр
Утас: 311554

Тооцооны 31-р төв

18-р хороо, "Лхатушиг"
ХХК-ын дэлгүүрийн байр
Утас: 357673

ХАН-УУЛ ДҮҮРЭГ

Тооцооны 6-р төв

1-р хороо, 120 мянгатын, 21-р байр
1-р орц, 2 тоот
Утас: 342102

Тооцооны 16-р төв

Нисэх, 64-р байрны 4-р орц, 46 тоот
Утас: 379776

Тооцооны 21-р төв

6-р хороо, Эрүүл мэндийн 13-р төв
Утас: 379306

Тооцооны 8-р төв

3-р хороо, ХУД-ийн шүүхийн байранд
Утас: 343293

БАЯНГОЛ ДҮҮРЭГ

Тооцооны 3-р төв

7-р хороо, 4-р хорооллын эцсийн буудал
Утас: 360702

Тооцооны 7-р төв

13-р хороо, 3-р хорооллын үйлчилгээний төв
Утас: 368091

Тооцооны 12-р төв

18-р хороо, 4-р хороолол
Симба ХХК-ийн байранд
Утас: 368989

Тооцооны 22-р төв

12-р хороо, 6-р бичил хороолол, 5Б-73 тоот
Утас: 302760

Тооцооны 26-р төв

4-р хороо, 2 дугаар хороолол
Дан цагаан байшин
Утас: 367327

Тооцооны 32-р төв

12-р хороо
БГД-ийн нийгмийн даатгалын газар
Утас: 369491

СҮХБААТАР ДҮҮРЭГ

Тооцооны 2-р төв

4-р хороо, 50 мянгатын 20-р байр, 4-р орц
Утас: 323257

Тооцооны 13-р төв

5-р хороо, Тээврийн товчоо
Үйлчилгээний байр
Утас: 327050

Тооцооны 14-р төв

8-р хороо, "Эвт" компанийн байранд
Утас: 350295

Тооцооны 30-р төв

Сангийн яамны байранд
Утас: 329826

Тооцооны 9-р касс

Засгийн газрын ордон
Утас: 372801

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

Тооцооны 15-р төв

16-р хороо, Хар хорин захын ард
Үйлчилгээний байранд
Утас: 684480

Тооцооны 17-р төв

12-р хороо, 2-р байр 12-397
Утас: 681961

Тооцооны 18-р төв

19-р хороо
Нийгмийн даатгалын хэлтсийн байр
Утас: 632243

Тооцооны 24-р төв

Баянхошууны, 9-р хорооны дэргэд
Утас: 306072

Тооцооны 29-р төв

18-р хороо, 6-р байрны хойд талд
Утас: 635828

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

Тооцооны 10-р төв

3-р хороо
"Сансар" үйлчилгээний төв
Утас: 451290

Тооцооны 11-р төв

5-р хороо, 10-р хороолол, 14Б байр, 1-р орц
Утас: 686836

Тооцооны 9-р төв

19-р хороо, Тунгалаг булаг ХХК-ын
үйлчилгээний төвийн байранд
Утас: 455017

Тооцооны 20-р төв

15-р хороолол, 97-р сургуулийн баруун талд
Утас: 456082

Тооцооны 27-р төв

6-р хороо
Көкүшүзэн хөгжил сангийн барилгын 4 тоот
Утас: 450730

Тооцооны 33-р төв

Ботаникийн эцсийн буудал
"Бадмаараг" ХХК-ийн байр
Утас: 90158120

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

1. Худалдаа Хөгжлийн банкны төв
2. ХХБ 801-р салбар /Дорнод аймаг/
3. ХХБ 802-р салбар /Сэлэнгэ аймаг/
4. ХХБ 803-р салбар /Дархан-Уул аймаг/
5. ХХБ 804-р салбар /Энхтайваны гудамж, 11-А/
6. ХХБ 805-р салбар /БГ дүүрэг, Замчны гудамж 36/
7. ХХБ 806-р салбар /Чингисийн өргөн чөлөө 10/
8. ХХБ 807-р салбар /Орхон аймаг/
9. ХХБ 808-р салбар /Дорноговь аймаг/
10. ХХБ Тооцооны төв-1 /Бунт-Ухаа ОУНОБ/
11. ХХБ Тооцооны төв-2 /Худалдааны гудамж/
12. ХХБ Тооцооны төв-3 /Доос гол ХХ-ий байранд/
13. ХХБ Тооцооны төв-4 /Дорноговь аймаг, Замын-Үүд/
14. ХХБ Тооцооны төв-5 /Сэлэнгэ аймаг/
15. ХХБ Тооцооны төв-6 /Ард Аюушийн өргөн чөлөө/
16. ХХБ Тооцооны төв-7 /Дархан-Уул аймаг, Хонгор/

БЭЛЭН МӨНГӨНИЙ АВТОМАТ МАШИН-АТМ


1. Худалдаа хөгжлийн банкний төв
2. ХХБ 804-р салбар /Энхтайваны гудамж 11-А/
3. Улаанбаатар зочид буудал
4. Чингис зочид буудал
5. Баянгол зочид буудал
6. Палас зочид буудал
7. Мастер Фудс /Сөүлийн гудамж, хуучнаар 50-р дэлгүүр/
8. Баянгол дүүрэг, холбооны 24-р салбар /3-р хороолол/
9. Амно супермаркет /4-р хороолол, Амно төв/
10. Миний дэлгүүр-2 /1-р хороолол, Хархорин захын ард/
11. Миний дэлгүүр-4 /1-р хороолол, хуучнаар Саппоро/
12. Идэр плаза /ТБД Андуудын жажууд/
13. Одод вояж зочид буудал /Төмөр зам/
14. Бунт-Ухаагийн ОУНОБ/Буудал



ХАДГАЛАМЖИЙН БЭЛЭН МӨНГӨ



АНКНЫ ВИЗА КАРТААР ОЛГОХ ЦЭГҮҮД



КАРТ АШИГЛАХ АМХАН ШАТНЫ ЗААВАР

Пин код

- Пин КОД бүхий дугтуйг зааврын дагуу задлах
- Пин кодоо цэвэрлэсний дараа пин дугтуйг даруй устгах
- Пин кодын нууцлалыг харниуцах

Картаг холбоотой

- Картаг сэжсэн буюу алдсан тохиолдолд 324896 утас руу залган яаралтай КАРТЫН ДАНСАА хаалгах
- Картаг бусад дэмжүүлэггүй банк
- Та картаг хүлээн авсан даруй картын ар талын гарын үсэг зурах талбай дээр тосон балзар өөрийн баталгаат ГАРЫН ҮСГЭЭ зурна уу!

АТМ хэрэглэхтэй холбоотой

- АТМ-ын дэлгэцэн дээр гарч буй ЗААВРЫН дагуу ажиллах
- Дансаа сонгохдоо ХАРИЛЦАХ ДАНС-ыг сонгох
- Картаг гарч ирсэн даруйд нь явах (амсар дээр нь удааж болохгүй) 24 цагаар 324896 утсаар холбогдон өөрийн картын үлдэгдэл болон картын үйлчилгээтэй холбоотой мэдээллийг авах боломжтой.

АТМ /Бэлэн мөнгөний машин-тай ажиллах заавар

1. КАРТЫГ АШИГЛАХ
2. ПИН КОДЫГ ОРООХ
3. ХЭЛЭЭНИЙГ ТАНИЛГАХ
4. АВАХ МӨНГӨНГӨЙ АЖИЛЛАХ
5. ТА ДАНСАА СОНГОНО УУ?
6. ТА АВАХ МӨНГӨНГӨЙ АЖИЛЛАХ
7. АВАХ МӨНГӨНГӨЙ АЖИЛЛАХ
8. АВАХ МӨНГӨНГӨЙ АЖИЛЛАХ
9. АВАХ МӨНГӨНГӨЙ АЖИЛЛАХ
10. АВАХ МӨНГӨНГӨЙ АЖИЛЛАХ
11. АВАХ МӨНГӨНГӨЙ АЖИЛЛАХ
12. АВАХ МӨНГӨНГӨЙ АЖИЛЛАХ
13. АВАХ МӨНГӨНГӨЙ АЖИЛЛАХ

өдрүүдэд 21.00 хүртэл
гаар ажиллаж бэлэн мөнгө



Худалдаа Хөгжлийн Банкны салбарууд



Бэлэн мөнгөний автомат машин - АТМ

ийн дагуу

Худалдаачийн Банк, Картын төв, Тосгоны 1-р тав 1-р хороо, бага тохруу, 1-40000
Утас: 976-11-324896,
Факс: 976-11-330393
E-mail: Cardcenter@savingsbank.mn

